

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН
2023-2024 оны хичээлийн жилийн зорилго, зорилт**

Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан цэцэрлэг, сургуулийн менежментийг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гаргах зорилгыг 2023-2024 оны хичээлийн жилд дэвшүүлж байна.

Энэ зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

1.Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийг суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтан, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, тэдний оролцоотой хэрэгжүүлэх;

2.Малчин болон алслагдсан бүс нутагт амьдарч байгаа өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг хувилбарт сургалт, үйл ажиллагаагаар дэмжих, 5 настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулан сургуульд элсэн суралцах бэлтгэл хангах;

3.Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн бүтцийг шинэчлэн тогтоож, аймаг, дүүрэг бүрд хоёр хүртэл ахлах сургуулийг 2024-2025 оны хичээлийн жилээс хичээллүүлэх бэлтгэл хангах;

4.Тэгш хүртээмжтэй, тэгш боломж олгосон, хамтын хариуцлагатай байх суурь зарчимд тулгуурлан байршлаас хамаарсан үйлчилгээний чанарын ялгааг бууруулж хүүхэд бүр гэртээ ойр байрлах цэцэрлэг, сургуульд хамрагдах хүсэл эрмэлзэлийг нэмэгдүүлэх;

5.Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах;

6. Суралцагчийн математик, англи хэлний сургалтыг дэмжих цахим технологи (сургалтын платформ)-д суурилсан нэмэлт хөтөлбөрийг бага, суурь боловсролын зарим ангид хэрэгжүүлж, суралцагчийн ур чадвар, багшийн арга зүйд ахиц гаргах;

7.Суралцагчдын шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэн судлах арга барил эзэмшүүлэх нэгдмэл агуулга бүхий төсөлт ажлыг анги, бүлгээс үл хамааран багаар хамтран гүйцэтгүүлж үр дүнг улирал бүр тооцох;

8.Цэцэрлэг, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багшийн мэргэжлийн хөгжлийн үндэсний цахим системийг ашиглан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох;